ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго:	“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх
Хугацаа:	Нэмж хувьцаа гаргах ажил ажил амжилттай хэрэгжиж дуустал
Байршил:	Улаанбаатар хот. Монгол улс

1. **Оршил**

Монгол Улсын Их Хурал 2011 онд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг баталж, хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 29 тоот тогтоол гаргаж гүйцэтгэх засаглалд даалгасны дагуу Засгийн газрын 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2013 оны 40 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Тус компани нь Монголын хөдөө аж ахуйн салбарын бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжих оновчтой тогтолцоог бий болгох замаар малчид, хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулж, хөрөнгийн санхүүжилтэнд хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагч этгээдэд оруулсан хөрөнгөнд нь тохируулан нэмэлт хувьцаа гарган эзэмшүүлэн хувьчлахаар заасан.

Энэхүү ажлын хүрээнд тус компанийн үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргах, хувьчлалын үйл ажиллагааны явцад хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн фирмийг сонгон шалгаруулж, хамтран ажиллах шаардлага гарч байна.

2. **Ажил үүргийн хуваарь:**

Зөвлөх нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргах;
2. Хувьчлалын үйл ажиллагаа эхлэн хувьчлал амжилттай хэрэгжиж дуусах хүртэл хугацаанд хууль эрх зүйн асуудлаар зөвлөгөө, хууль зүйн туслалцаа үзүүлэх.

3. **Ажил гүйцэтгэх хугацаа:**

Хувьчлалын үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж дуусах хүртэл хугацаанд хийгдэнэ.

4. **Төлбөрийн нөхцөл:**

Гэрээгээр тохиролцсон нөхцөлийн дагуу төлбөрийг гүйцэтгэнэ.

5. **Зөвлөхөд тавигдах шаардлага:**

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хууль эрх зүйн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульчдаас бүрдсэн хуулийн фирм байх;
- Үнэт цаасны зах зээлд хувьцаа гаргах талаар хууль эрх зүйн дүгнэлт гаргаж ажиллаж байсан ажлын туршлагатай бол давуу тал болно.